



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 01/01

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, "Инновэйшн инвестмент" ХК (цаашид "Компани" гэх)-ийн Дүрмийн 23 дугаар зүйл, Компанийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.8.7 дахь заалт болон "Ногдол ашгийн бодлого"-ыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нийт эргэлтэнд гарсан 184,889,160 (нэг зуун наян дөрвөн сая найман зуун наян есөн мянга нэг зуун жаран) ширхэг энгийн хувьцаанд нийт 9,244,458,000.00 (есөн тэрбум хоёр зуун дөчин дөрвөн сая дөрвөн зуун тавин найман мянган) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 50 (тавин) төгрөгөөр тогтоосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар, хуулийн этгээдийн хувьд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иар дамжуулан 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Компанийн хувьцаа эзэмшигчдийн дансанд олгосугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгох шийдвэрийг хүргэх болон ногдол ашиг хуваарилах ажлыг зохион байгуулж энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б. Энхболд/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР